ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН
ЭНХЖАРГАЛЫН БУДХАНДЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" (ЧИГ ҮҮРЭГ) | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1<br>Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт тавих | Санхүүжилтийн дүн, сая төгрөг<br>Хэрэгжилтийн хувь | 100% | 50% | Тайлант хугацаанд захиалагчийн хяналт тавих ажил ирээгүй болно. | 01.01-12.31 | - |
| 2 | Арга хэмжээ 1.2<br>Өмнө онуудад хэрэгжин захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгө болон чанарын баталгааг чөлөөлөх | Иргүүлсэн хүсэлтийн тоо, хөрөнгийн хэмжээ | 100% | 30% | 1. Саммит компьютер техноложи" ХХК-ийн "Хот байгуулалт, хөгжлийн газар"-т нийлүүлсэн тоног төхөөрөмжийн 5 % болох **8,892,783.5** (найман сая найман зуун ерэн хоёр мянга долоон зуун наян гурван төгрөг тавин мөнгө) төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлж олгосон.<br>2. Юнитра" ХХК-ийн "Геодези, усны барилга байгууламжийн газар"-т нийлүүлсэн "Ус Зайлуулах насос" тоног төхөөрөмжийн 5% болох **2,695,000** (хоёр сая зургаан зуун ерэн таван мянга) төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлж олгосон.<br>3. Юнитра" ХХК-ийн "Геодези, усны барилга байгууламжийн газар"-т "Бужигнуулагчтай лаг шаврын насос" тоног төхөөрөмжийн 5% болох **6,242,500** (зургаан сая хоёр зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлж олгосон. | 01.01-12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ 1.3<br>Байгууллагын тайлан баланст бүртгэлтэй барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих | Ирсэн зөвлөмж, хяналт дүн шинжилгээний тоо | 100% | 50% | Газрын даргын 2024 оны 4/03 дугаар байр талбайн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Багахангай, Сүхбаатар дүүргийн нийт 51 төсөвт, 3 өмчит үйлдвэрийн газрын байр талбайг шалгалт хийж зөрчлийн дагуу зөвлөмж өгч ажиллаж байна. | 01.01-06.05 | 100% |
| 4 | Арга хэмжээ 1.4<br>Түрээсийн сонгон шалгаруулалтад гишүүнээр оролцон хяналт тавих | Сонгон шалгаруулалтын комиссын тоо<br>Түрээсийн үнэ | 100% | 50% | Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/83 тоот даргын тушаалын дагуу Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах Нийслэлийн төр захиргааны байр буюу Шинэ Хангарди цогцолборын байранд "Кофе шоп"-ийн зориулалтаар, Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо Сансар зочид буудлын хажуу 35,65 мкв талбайг "Албан тасалгаа"-ний зориулалтаар, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо Үйлст нэгтэн ерхийн эмнэлгийн 150 мкв байрыг "Албан тасалгаа, Үйлдвэр үйлчилгээ, бусад" чиглэлээр тус тус түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс орж ажилласан. | 01.01-12.31 | 100% |
| 5 | Арга хэмжээ 1.5<br>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 50% | 1.Байгууллагын 2023 онд зохион байгуулсан илүүдэлтэй байр талбайн сонгон шалгаруулалтын байдалд шалгалт хийн ажлын тайланг танилцуулсан.<br>2. Газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу 2023 оны түрээсийн гэрээ дүгнэх ажлын хэсэгт орж Хан-уул, Сонгинохайрхан, Багахангай дүүрэгт түрээсийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийт 26 байр талбайг газар дээр нь шалган зөрчилтэй 10 газрын байр талбай чөлөөлөх, түрээсийн төлбөрөө төлж дахин сонгон шалгаруулалт явуулан гэрээ байгуулах, өмнөх оны өр төлбөрийг барагдуулах албан бичгүүдийн тус тус хүргүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.<br>3. Газрын даргын 2024 оны 4/032 хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу Багахангай, Сүхбаатар дүүргийн нийт 51 төсөвт, | 01.01-12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3 өмчит үйлдвэрийн газрын байр талбайг үзэж хяналт, шалгалт хийж холбогдох зөвлөмжийг өгч, мэдээллийг удирдах албан тушаалтанд танилцуулсан.<br>4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 03 дугаар сарын 13 ны өдөр СХД-ийн 22 товчооны орчим байрлах объектыг газар дээр нь очиж үзэхэд төмөр хашаатай дотроо олон тооны тээврийн хэрэгсэл, 1 сэндвичэн барилга, 3-4 төмөр контейнер байсныг зураг авч баталгаажуулан танилцуулсан.<br>5. "Монголын бурхан шашинтны шинэ төв" нь Дамбадаржаа хийдийн Цогчин дуганы барилга байгууламжийг чөлөөлж, хүлээлгэн өгөх мэдэгдлийн дагуу хүлээлгэж өгөөгүй тул 2024.02.16-ны, 03. 20-ны өдөр Дамбадаржаалин хийдийн Да лам О.Лхагвасүрэн, манаач Н.Раднаа нарыг байлцуулан Цогчин дуганы нийт 6 хаалгыг мэдэгдэх хуудас нааж лацадсан.<br>6. Баянгол дүүргийн 14-р хороо 3-р хороолол Монгол шуудан МКШ-ийн 24-р салбарын түрээслэгч "Тэмүүжин групп"-ын дам түрээслэгч нартай хэлэлцээр хийсний дагуу шууд түрээсийн гэрээнд иргэдээр гарын үсэг зуруулсан.<br>8. Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, нийслэлийн өмчийн байранд байрлах Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв нь Чандмань уламжлалт эмийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байсныг байр, талбай чөлөөлөх мэдэгдлийг 04 дүгээр сарын 09, 25-ны өдрүүдэд өгч гарын үсэг зуруулж, барилгын гадаах 3 хаалган дээр нь мэдэгдэх хуудас нааж холбогдох зургийг авч баталгаажуулсан.<br>9. Нийслэлийн Засаг даргын 2023.11.17-ны эрх шилжүүлэх тухай А/1311 дугаар захирамжийн дагуу АОДЭ ХХК-аас нийлүүлсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | HOWO маркийн өөрөө буулгагч машин механизмыг Сэлэнгэ аймгийн "Тохилог хараа" ОНӨААТҮГ-Т 1, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газарт 1ш, "Ус сувгийн удирдах газарт-3, "Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-Т 3, "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОӨНААТҮГ-т 3, "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ-т 1, нийт 12 машин механизмыг акт үйлдэн тус тус хүлээлгэн өгсөн.<br>10. Нийслэлийн засаг даргын А/287 дугаар захирамжаар олгосон 70 байршил газар нь газар кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем "Лэнд менежер" программд зарим нэгж талбарын нэр зөрүүтэй, иргэнийн нэр дээр бүртгэлтэй зөрчил арилгуулах албан бичгийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Хариу албан бичгээр ирүүлсэн 66 нэгж талбарыг шалгахад НӨХГ-ын нэр дээр 39, иргэний нэр дээр 27 нэгж талбарын мэдээлэл орсон байна. Бусад Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 4 нэгж талбарын хувийн хэрэг тус албаны архивд хадгалагдаагүй, нөхөн бүрдүүлэлтээр оруулах боломжтой гэсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/287 дугаар захирамжаар манай байгууллагад газар эзэмших эрх олгосон 27 байршил газрыг манай байгууллагын нэр дээр шилжүүлэн кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд баталгаажуулан, газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгох тухай Байгууллагын 2024 оны 4/917 албан бичгээр дахин хүргүүлсэн. | | |
| **Зорилт 2 . Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| 6 | Арга хэмжээ 2.1<br>Байгууллагын дагаж мөрдөж байгаа салбарын хууль, тогтоол, дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлэх | Эрх зүйн актын тоо | 100% | 0% | Тайлант хугацаанд холбогдох хууль, тогтоол, дүрэм, журамд санал аваагүй болно. | 01.01-12.31 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Арга хэмжээ 2.2<br>Байгууллагын үйл ажиллагаанд MN ISO 9001:2016 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилд оролцох | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 0% | Тайлант хугацаанд MN ISO 9001:2016 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажил явагдаагүй. | 01.01-12.31 | - |
| **Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт - төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох** | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 3.1<br>Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | Албан бичиг Өргөдлийн тоо, хувь | 100% | 50% | Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системээр нийт **15** албан бичиг ирж хугацаанд нь шийдвэрлэж ажилласан бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа **4,53** байна. | 01.01-12.31 | 100% |
| 9 | Арга хэмжээ 3.2<br>ERP системийн өргөдөл гомдлын программаар иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдол, бусад байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн албан бичиг шийдвэрлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 50% | Тайлант хугацаанд иргэнээс **1** өргөдөл гомдол ирсэн бөгөөд хугацаанд нь **100%** шийдвэрлэсэн. | 01.01-12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрсэн түвшин | Биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэхэд ажиллах, хяналт тавих | Гэрээ дүгнэсэн байгууллагын тоо | 100% | 0% | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/90 тушаалаар "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх"-ийн 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах тухай" тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан -ийн Сонгинохайрхан дүүргийн 1 цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн 1 төв, нийт 2 байгууллагын "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн. | 01.01-06.10 | 100% |